"Эрдэнэс критикал минералс" ТӨҮГ-ын
2025 оны 12-р сарын 08-ны өдрийн
1/2066 дугаар албан бичгийн хавсралт

ERDENES CRITICAL MINERALS
ЭРДЭНЭС КРИТИКАЛ МИНЕРАЛС ТӨҮГ
УЛААНБААТАР ХОТ
012 ☎ 2550466

## "Эрдэнэс критикал минералс" ТӨҮГ-ын 2025 оны авлигын эсрэг үйл ажиллагааны тайлан

| № | Үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа | № | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төлөвлөгөөний биелэлт | Төсөв /сая төгрөг/ | Хариуцах нэгж, албан тушаалтан |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Авлигын эсрэг үйл ажиллагааны журам боловсруулж батлуулах | 1 | Авлигын эсрэг үйл ажиллагааны журмын төсөл боловсруулж батлуулах | II улиралд | Авлигын эрсдэлийг бууруулах, авлигаас урьдчилан сэргийлэх, шударга, ил тод байдлыг хангах, авлигын эсрэг үйл ажиллагаар үр дүнтэй зохион байгуулах | "Эрдэнэс Критикал Минералс" ТӨҮГ-ын захирлын 2025.04.18-ны өдрийн А/38 тоот тушаалаар "Авлигын эсрэг үйл ажиллагааны журам" -ыг баталсан. Үйлдвэрийн газрын хэмжээнд даган мөрдөн ажиллаж байна. | байхгүй | ДХМХ, ХЭЗХ |
| 2 | Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | 1 | АТГ-аас бэлтгэсэн контентыг (шторк,рийлс, видео, зурагт хуудас, гарын авлага гэх мэт), үйлдвэрийн газрын өөрийн цахим сүлжээ /фейсбүүк, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр ажилчдад, олон нийтэд хүргэсэн байх; | Тухай бүр | Баримтжуулж, үр дүнг тооцож тайлагнасан байх | АТГ-аас бэлтгэсэн контентыг(шторк,рийлс, видео, зурагт хуудас, гарын авлага гэх мэт) үйлдвэрийн газрын өөрийн фейсбүүк хуудас болон ажилчдын хаалттай групптнийтлэн хуваалцаж ажиллаж байна. Авлигатай тэмцэх газраас 2025 онд бэлтгэн гаргасан Нийтийн албан тушаалтнуудад зориулсан гарын авлагыг мэдүүлэг гаргах үүрэг бүхий албан тушаалтнуудад тараасан. | байхгүй | ДХМХ, ЗААХ, ХЭЗХ |
| | | 2 | Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг үйлдвэрийн газрын хэмжээнд зохион байгуулах | Тухай бүр | Дэмжиж хамтран ажилласан байх, үр дүнг тайлагнасан байх | Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж буй аливаа арга хэмжээ, мэдээ, мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан нийт ажилчдад хүргэж ажиллаж байна. | байхгүй | ДХМХ, ЗААХ, ХЭЗХ |
| 3 | | 1 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах | Хуулийн хугацаанд | Хуулийн хэрэгжилтийг хангаж хуульд заасан мэдээллийг хуулийн хугацаанд олон нийтэд нээлттэй байршуулсан байх | Шилэн дансан дахь тендерийн ерөнхий мэдээлэл болон гэрээний гүйцэтгэлийн мэдээллийг сар бүрийн 8-ны дотор олон нийтэд ил тод болгон байршуулж байна. Мөн гадаад томилолт, тэтгэмж тусламж олгох тушаал шийдвэрийг тухай бүр, орон тооны өөрчлөлтийг сар бүр хуулийн хугацаанд олон нийтэд нээлттэй байршуулсан. Үйлдвэрийн газрын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн тайланг "Эрдэнэс Монгол"ХХК-д улирал бүр хүргүүлэн ажиллаж байна. | байхгүй | НББХ, ДХМХ, ХАБХ, ЗААХ, |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах, Байгууллага болон албаны нууцад хамааруулснаас бусад шийдвэр, тушаалын ил тод байдлыг хангах нөхцөл боломжийг бүрдүүлэх, цахим хуудсанд байршуулах | 2 | Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа дүрэм, журам, зааврыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах. / Сонгон шалгаруулалт, томилгоо, шагнал урамшуулал, сургалт тэтгэлэг, орон сууц олгох, түрээслүүлэх журам/ | Тухай бүр | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, шилэн дансны тухай хуулийн дагуу холбогдох мэдээллийг байршуулах | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан нээлттэй мэдээллийг шинэчлэгдсэн тохиолдолд цаг тухай бүрд нь үйлдвэрийн газрын www.ecmm.mn цахим хуудсанд ил тод байдал цэсэнд тогтмол байршуулан ажиллаж байна. Үйлдвэрийн газрын цахим хуудас болох www.ecmm.mn-д Ажлын байрны сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах журам, Хөдөлмөрийн дотоод журам, Ёс зүйн дүрэм, Үйлдвэрийн газрын зардлаар суралцаж буй оюутнуудын мэдээлэл, Архивын ажлын заавар журам, Байгууллагын дүрэм журам, Албан бичиг хөтлөлтийн журам зэргийг байршуулан ажиллаж байна. Үйлдвэрийн газрын харьяа Бор-Өндөр УБҮ нь өөрийн пэйж хуудсанд Шинэ ажилтан сонгон шалгаруулах журам, гадаад, дотоод сургалтын мэдээг ил тод, нээлттэй байршуулан ажиллаж байна. | байхгүй | ЗААХ, ХЭЗХ, НББХ, ДХМХ, ХАБХ, ТЭЗШХ |
| | | 3 | Дотоод болон хөндлөнгийн хяналт шалгалтын дүгнэлт, зөвлөмж, аудитын тайланг цахим хуудсандаа байршуулах | Хуулийн хугацаанд | | Шилэн дансны тухай хуулийн дагуу тухайн жилд үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд хийсэн аудитын тайланг хуулийн хугацаанд багтаан олон нийтэд ил тод мэдээллэн ажиллаж байна. Доорх холбоосоор орж үзэх боломжтой. /https://shilendans.gov.mn/organization/27094?ry=2023&rfor=63273&rf=1827&rm=12/ | | |
| | | 4 | Бараа, ажил үйлчилгээ нийлүүлэхээр гэрээлсэн аж ахуйн нэгжүүдийн нэр, ажил үйлчилгээ, гэрээний үнийн дүн, гүйцэтгэл зэрэг мэдээллийг жил бүрээр, гэрээлэгч бүрээр шүүж харах боломжтой байдлаар байршуулах | Хуулийн хугацаанд | | Бараа, ажил үйлчилгээ нийлүүлэхээр гэрээлсэн аж ахуйн нэгжүүдийн нэр, ажил үйлчилгээ, гэрээний үнийн дүн болон холбогдох мэдээллийг tender.gov.mn сайтад гэрээний хуулбарын хамт тухай бүр байршуулан ажилладаг.. | | |
| | | 5 | Борлуулалт, хөрөнгө оруулалт, худалдан авалт, зардал, төсөвт төвлөрүүлсэн орлого зэрэг мэдээлэл бүхий нэгдсэн тайлан гаргаж, олон нийтэд ил тодоор мэдээлэх | Хуулийн хугацаанд | | Шилэн дансанд хуулийн хугацаанд оруулан ажиллаж байна. | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 6 | Удирдлагын шийдвэр, тушаалын ил тод байдлыг хангах нөхцөл боломжийг бүрдүүлэх, цахим хуудсанд байршуулах | Тухай бүр | | Одоогоор байршуулаагүй байна. | | |
| 4 | Хүний нөөцийн удирдлага болон томилгооны ил тод, мэргэшсэн, тогтвортой байдлыг бэхжүүлэх | 1 | Удирдлага болон боловсон хүчний томилгоог хөндлөнгийн нөлөөллөөс ангид, ил тод нээлттэй, сонгон шалгаруулалт явуулах | Тухай бүр | Ажлын байрны зар болон сул орон тооны мэдээллийг холбогдох журмын дагуу ТӨҮГ-ын цахим хуудас болох www.ecmm.mn болон бусад сайтуудад байршуулах. Мэдээллийн ил тод байдлыг хангах | Ажлын байрны сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах журмын дагуу томилгоог нээлттэй ил тод явуулж байна. | | ЗААХ |
| | | 2 | Ажлын байрны зар болон сул орон тооны мэдээллийг цахим хуудсандаа байршуулах | Тухай бүр | Ажлын байрны зар болон сул орон тооны мэдээллийг холбогдох журмын дагуу ТӨҮГ-ын цахим хуудас болох www.ecmm.mn болон бусад сайтуудад байршуулах. Мэдээллийн ил тод байдлыг хангах | Ажлын байрны сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах журам-ын дагуу ажлын зар сул орон тоог тухай бүр ТӨҮГ-ын www.ecmm.mn цахим хуудаст, "Эрдэнэс критикал минералс" ТӨҮГ facebook пэйж хуудас, Бор-Өндөр УБҮ-ийн Захиргааны дэргэдэх Мэдээлэл сурталчилгаа, орон нутгийн нүүр номын "Бор-Өндөр" шуурхай зар, Бор-Өндөр зарын групп, Уул уурхайн нэгдсэн зар Ажлын зар, Уул уурхайн ажлын зар, Хэнтий зар группууд, "Шижир-Алт" АҮ-ийн вэб сайт, Заамар сум, Булган аймгийн Бүрэгхангай сумын facebook нэгдсэн групп, Хайлааст 3 дугаар багийн нэгдсэн групп, үйлдвэрийн ажилтнуудын группт болон үйлдвэр дээрх зарлалын самбарт нээлттэй байршуулан мэдээллийн ил тод байдлыг ханган ажилласан. | 12,113.00 | ЗААХ |
| | | 3 | ТӨҮГ-ын удирдах болон эрх бүхий албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газраар хянуулсны үндсэн дээр томилж байх | Тухай бүр | ХАСУМ гаргах чиг үүрэг бүхий албан тушаалтныг томилохоос өмнө АТГ-аар ХАСУМ-ийг хянуулсны үндсэн дээр томилох | ХАСХОМ мэдүүлэх үүрэг бүхий албан тушаалтаныг томилохоос өмнө АТГ-т ХАСУМ-ийг хянуулан, зөрчилгүй гэсэн дүгнэлтийг үндэслэн томилгоог хийж байна. 2025 онд нийт 16 албан тушаалтны ХАСУМ-ийг урьдчилан хянуулж томилсон. | байхгүй | ЗААХ, ДХМХ |
| 5 | Төсөв, санхүүгийн удирдлага, хяналтыг сайжруулах, хариуцлагыг дээшлүүлэх | 1 | Удирдлагаас тушаал, шийдвэр гаргахдаа хууль тогтоомжид нийцүүлэн гаргах | тогтмол | Холбогдох хууль тогтоомжийн биелэлтийг хангах | 2025 оны 12дугаар сарын 8-ны өдрийн байдлаар Захирлын үйл ажиллагааны 366 Тушаалд, Хүний нөөцийн 201 тушаалд ХЭЗХ-ийн зүгээс хяналт тавин хууль тогтоомжид нийцүүлэн ажилласан байна. | байхгүй | СНББХ, ТЭЗШХ, ЗААХ, ХЭЗХ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөлт, менежмент, зохион байгуулалтыг боловсронгуй болгох | 1 | Худалдан авалтыг үйлдвэрлэлийн бодит хэрэгцээ, шаардлагад тулгуурлан төлөвлөж буй эсэхэд хяналт шалгалт хийх | тогтмол | Үйлдвэрлэлийн хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлсны үндсэн дээр худалдан авалтын төлөвлөгөөг зөв оновчтой төлөвлөх, илүүдэл нөөц үүсгэхгүй байх | Үйлдвэрлэлийн хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлсны үндсэн дээр худалдан авалтын төлөвлөгөөг боловсруулж батлуулсан ба төлөвлөгөөнд тусгагдаагүй боловч зайлшгүй худалдан авах шаардлагатай болсон сэлбэг, бараа материалыг хуулийн дагуу төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах 2 удаагийн тодотгол хийсэн. | байхгүй | ХАБХ |
| | | 2 | Тендерийн үнэлгээний хорооны хараат бус гишүүдийг сонгох үйл ажиллагааг боловсронгуй болгох | тогтмол | Тендерийн үнэлгээний хорооны шийдвэр үндэслэлтэй гарах, хараат бус гишүүдийн хяналт сайжрах | Тендерийн үнэлгээний хорооны хараат бус гишүүдийг олон нийтэд нээлттэй зар байршуулан сонгон шалгаруулах ажиллагаа явуулсаны үндсэн дээр санал ирүүлсэн 2(хоёр) ТББ-ын 17 гишүүнтэй хамтран ажиллаж байна. | 52,000.00 | ХАБХ |
| 7 | Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдыг АТГ-аас зохион байгуулах сургалтад хамруулах | 1 | Авлигын эсрэг сургалтын санал, захиалгыг АТГ-ын УССГХ-т хүргүүлж, хамтран ажиллах | Жил бүр | Албан бичгээр сургалтад хамрагдах санал хүргүүлж хамтран ажиллах | АТГ-аас авлигын эсрэг сургалт авахаар цахимаар хүсэлтээ хүргүүлэн ажиллаж байна. | байхгүй | ДХМХ, ЗААХ |
| | | 2 | АТГ-аас зохион байгуулдаг авлигын эсрэг анхан болон давтан сургалтад ажилтан албан хаагчдыг хамруулсан байх | | Сургалтад хамрагдсан ажилтан албан хаагчдын тоо, идэвхи оролцоо | АТГ-аас 2025.02.07-ны өдөр зохион байгуулсан "Авлига, ашиг сонирхлын зөрчил, авлига албан тушаалын гэмт хэрэг, хор хөнөөл" сэдэвт сургалтад танхимаар 41, цахимаар 14 нийт 55 ажилтан хамрагдсан. АТГ-аас 2025.11.20-ны өдөр зохион байгуулсан Авлигын эсрэг цахим сургалтад тус үйлдвэрийн газрын харьяа "Бор-Өндөр" УБҮ-аас нийт 110 ажилтан хамрагдсан. АТГ-аас 2025.12.01-ний өдөр зохион байгуулсан ХАСХОМ-ийн бүрдүүлэлтийн цахим системийн шинэчлэлтэй холбоотой цахим сургалтад ЭБАТ хамрагдсан. | | |
| | | 1 | Авлигын эсрэг үйл ажиллагааны хэрэгжилтийн тайланг тогтсон хугацаанд АТГ-т хүргүүлэх | IV улиралд | Төлөвлөгөөний гүйцэтгэлийг гаргаж, тайланг хүргүүлсэн байх | ТӨҮГ-ын 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны хэрэгжилтийн тайланг гарган ТӨБЗГ-т хүргүүлсэн. 2025 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг тайлант хугацаанд хүргүүлэн ажиллаж байна. | байхгүй | ЭБАТ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 8 | Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх | 2 | Авлигатай тэмцэх олон улс, үндэсний стандартыг нэвтрүүлж, бизнес комплайнс тогтолцоо зэрэг арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх | IV улиралд | "ISO37001 Авлигын эсрэг менежментийн тогтолцоо" стандартыг талаар мэдлэг ойлголт өгөх сургалт, уулзалтад зохион байгуулах | Ворлд стандарт консалтинг академиас ТӨҮГ-т "ISO 37001 Авлигын эсрэг менежментийн тогтолцоо" стандартын талаар 1 өдрийн сургалтыг 2024 оны 10 дугаар сард зохион байгуулсан. ХАСХОМ гаргах эрх бүхий нийт 26 албан тушаалтаныг уг сургалтад хамруулсан. Үйлвэрийн газарт "ISO37001 Авлигын эсрэг менежментийн тогтолцоо" стандартын зөвлөх үйлчилгээ авахаар төсвийг 2026 оны бизнес төлөвлөгөөнд тусгуулсан. | 6,000.00 | Бүх ажилчид |
| 9 | Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг нь хугацаанд нь мэдэгдэх | 1 | Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж | I-IV улиралд | Арга хэмжээг хэрэгжүүлэн хариу тайланг хүргүүлсэн байх | АТГ-ын дэргэдэх Олон нийтийн зөвлөлөөс ирүүлсэн зөвлөмжийг ТӨҮГ-ын 2025 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган ажиллаж байна. | байхгүй | ДХМХ, холбогдох бүтцийн нэгжүүд |
| | | 2 | Мөрдөгчийн мэдэгдэл | | | Мэдэгдэл ирээгүй. | | |
| | | 3 | Зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээ | | | Албан бичиг ирээгүй. | | |
| 10 | Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх | 1 | Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга /уриа, уриалга, мэдэгдэл, амлалт г.м/-д нэгдэх, дэмжиж оролцох | Тухай бүр | Санал , санаачилга, аянд нэгдэж, өөрийн цахим сувгаар түгээсэн байх | МУХАҮТ-аас ирүүлсэн "Авлигын эрсдэлийг дотооддоо хангах заавачилгаа"-г ТӨҮГ-ын захиргааны дотоод сүлжээ болон FB группт байршуулж , мөн захиргааны нийт 60 ажилтанд мэйлээр хүргүүлэн ажилласан. | байхгүй | ДХМХ,ЗААХ, ХЭЗХ, холбогдох нэгжүүд |
| | | 2 | Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах | Тухай бүр | Бусад байгууллагатай байгуулж буй гэрээнд заалт болгон оруулсан байх | 2025 оны 1/846 дугаартай албан бичгээр ТӨҮГ-ын хэлтэс болон харьяа үйлдвэр, бүтцийн нэгжүүдэд бүх төрлийн гэрээ байгуулахдаа Авлигын эсрэг хууль тогтоомжийг мөрдөн ажиллаж, авлигаас урьдчилан сэргийлж, авлигын талаарх мэдээллийг холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдэж ажиллах агуулга бүхий заалтыг тусгаж ажиллахыг үүрэг болгосон. | | ХЭЗХ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 11 | Авлига ашиг сонирхлын зөрчил үүсэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах | 1 | Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, авлигын эрсдэлийг тодорхойлох, эрсдэлийн үнэлгээ хийх г.м/ | II-улиралд | Үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байдлаар дүгнэнэ. | МУХАУТ-аас ирүүлсэн "Авлигын эрсдэлийг дотооддоо хангах зааварчилгаа"-г ТӨҮГ-ын захиргааны дотоод сүлжээ болон FB группт байршуулж , мөн захиргааны нийт 60 ажилтанд мэйлээр хүргүүлэн, үйлдвэрийн газрын захиргааны хэмжээнд авлигын эрсдэлээ тодорхойлохоор ажиллаж байна. Харъяа үйлдвэр болох "Бор-Өндөр" УБҮ-т ажиллаж байгаа нийт 173 ИТА, 49 албан хаагчдаас "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх баталгаа" гаргуулан авсан ба албан бичиг, хүсэлт зэргийн үе шат, дамжлагыг бууруулах зорилгоор цахимжуулах үйл ажиллагаа хийгдэж байна. | байхгүй | ДХМХ, холбогдох бүтцийн нэгжүүд |
| 12 | Аливаа нийтлэл, нэвтрүүлэг, зар сурталчилгаа, мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэхтэй холбогдсон үйл ажиллагааг нээлттэй ил тод болгоно. | 1 | Үйлдвэрийн газраас хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтын ажиллагааны хүрээнд байгуулсан аливаа гэрээ, хэлцэл, түүний гүйцэтгэл олон нийтэд нээлттэй, ил тод байлгах | Тухай бүр | Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтын ажиллагааны хүрээнд байгуулсан гэрээг нийтэд ил тод болгох | 2025 онд"Эрдэнэс Критикал Минералс" ТӨҮГ нь "Монгол Ньюс" ХХК-тай "Өнөөдөр" Сонин захиалгын гэрээ байгуулан ажиллаж байна. Энэхүү гэрээг үйлдвэрийн газрын цахим хуудас болох www.ecmm.mn-нд үйл ажиллагааны ил тод байдал цэсэнд байршуулан ажиллаж байна. | байхгүй | ХЭЗХ |
| 13 | Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт болон зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах | 1 | Үйлдвэрийн хэмжээнд гомдол, мэдээлэл авах, нягтлан шалгах үйл ажиллагааг боловсронгуй болгох, ёс зүйн хорооны үйл ажиллагааг сайжруулах бүрэлдэхүүнд хараат бус хөндлөнгийн гишүүн оруулах | Тухай бүр | санал гомдол, мэдээлэл хүлээн авах, нягтлан шалгах, шийдвэрлэх тогтолцоо ажилладаг болно. Ёс зүйн хорооны үйл ажиллагаа сайжирна | 2025 оны А/161 дугаар тушаалаар Ёс зүйн дүрмийг шинэчлэн баталсан бөгөөд дүрмийн хүрээнд ёс зүйн хороо байгуулан хэрэгжилтийг хангуулах ажиллаж байна. | байхгүй | Бүх бүтцийн нэгжүүд |
| | | 2 | Өргөдөл гомдол, зөрчлийн талаар мэдээлэл хүлээн авах ажил үүргийг хариуцсан ажилтны нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, цагийн хуваарийг цахим хуудсанд байршуулах | II-улиралд | Өргөдөл гомдол хүлээн авах суваг тодорхой болно | Цахим хуудсанд байршуулсан. | байхгүй | ЗААХ |
| | | 3 | Иргэд, аж ахуй нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, албан бичгийг цахим системд бүртгэж шийдвэрлэлтийг хянах боломжийг бүрдүүлэх | Тухай бүр | Өргөдөл гомдол, албан бичгийн шийдвэрлэлт хариуцагч эзэнтэй цаг хугацаатай болно | Иргэд, аж ахуй нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, албан бичгийг ERP цахим системд бүртгэн хяналт тавьж ажилладаг. | байхгүй | ЗААХ |

-----oo0oo-----